

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 06 дугаар сарын 29

Дугаар 49

Улаанбаатар хот

Үйлчилгээний хураамжийн хэмжээг
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Соёлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалт, дүүргийн Засаг даргын 01/580 тоот албан бичгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын долдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Баянзүрх дүүргийн Соёлын ордны үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчилж, хавсралтаар баталсугай.

2. Үйлчилгээний хураамжийн хэмжээг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Соёлын ордны дарга (Л.Рэнчинням)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан)-д үүрэг болгосугай.

4. Тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/16 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06
дугаар сарын 29-ний өдрийн долдугаар
хуралдааны 49 дүгээр тогтоолын
хавсралт

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН СОЁЛЫН ОРДНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

1.Дугуйлан секц			
Д/Д	Үйлчилгээний нэр төрөл	Хураамжийн хэмжээ (1 сар)	1 удаагийн арга хэмжээ
1	Дууны анги	30,000	
2	Бүжгийн анги	30,000	
3	Уртын дууны анги	30,000	
4	Драмын анги	30,000	
5	Морин хуурын анги	30,000	
6	Шанз, төгөлдөр хуурын анги	30,000	
7	Ёочин хөгжмийн анги	30,000	
2. Олон нийтийн арга хэмжээ			
8	Нийтийн цэнгээнт бүжиг		2000
9	Баянзүрх дүүргийн харьяа хэлтэс, алба		300,000 (Дүүргийн төсөвт байгууллагад хамаарахгүй)
10	Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, дүүргийн хороод		Үнэ төлбөргүй (Албан бичигт үндэслэн 1-2 удаагийн арга хэмжээ)
11	Хурал		300,000
12	Лекц сургалт		500,000
13	Кино үзвэр		5000 (Хүүхэд) 8000 (Том хүн)
14	Концертын арга хэмжээ		500,000 (1 цаг)
15	Захиалгат соёл олон нийтийн арга хэмжээ		500,000 (1 цаг)
16	Цэнгээнт бүжгийн танхим ашиглах		300,000 (1 цаг)
3. Хөгжим техникийн үйлчилгээ			
17	Техник аппаратаар гадуур үйлчлэх		300,000 (1 цаг)
18	Даралтат хөгжмөөр үйлчлэх		200,000 (1 цаг)
19	Ардын үндэсний хөгжмөөр үйлчлэх		50,000 (1 цаг)
20	Явуулын тайз, дэлгэц		500,000 (1 цаг)
21	Лед дэлгэц		300,000 (1 цаг)